



From
the People of Japan

ЯПОН УЛСЫН ЗЛЧИН САЙДЫН ЯАМ
Улаанбаатар хот 14210, Злчингийн гудамж 10,
Төв шуудан ш/х 1011, Монгол улс
Tel: +976-11-320777
Fax: +976-11-313332



ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН “ӨВСНИЙ ҮНДЭС-ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨР



ХӨТЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



ЯПОН УЛСЫН ЗЛЧИН САЙДЫН ЯАМ



ГАРЧИГ

1. Япон улсаас Монгол улсад үзүүлж буй тусламж	2
2. “Өвсний үндэс” хөтөлбөрийн танилцуулга	2-4
3. Хэрэгжсэн төслүүдийн статистик тоон үзүүлэлт	5-7
4. Төсөл хэрэгжсэн газруудын газар зүйн байрлал	8-9
5. Төсөл хэрэгжсэн газруудын фото зургууд	10-17
6. Төсөл хэрэгжсэн байгууллагуудын талархлын үгс	18-23
7. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн төслийн жагсаалт	24-40



ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЖ БҮЙ ТУСЛАМЖ

Япон улс нь Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-аар дамжуулан хөгжиж буй орнуудад цаг үетэй хамт өөрчлөгдөн тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж ирсэн. Япон улсын Засгийн газар нь Монгол улсын эдийн засаг болон хүмүүнлэгийн салбарт тусламж үзүүлснээр бүс нутаг хийгээд дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг хангахыг зорьж байна.

1972 онд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон ба 1977 онд Япон улс “Говь” үйлдвэрийг барихад буцалтгүй тусламж үзүүлсэн. 1990 онд ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө социалист тогтолцоотой байсан БНМАУ-д Япон улсаас үзүүлэх тусламж нь “Говь” үйлдвэрийн техникийн тусламж төдийхнөөр хязгаарлагдаж байв.

1990 оны Монгол дахь нийгмийн тогтолцооны өөрчлөлт нь эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг зэрэг үнэт зүйлсийг бидэнтэй хуваалцах боломжийг нээснээр Япон улс 1-рт Монголын эдийн засгийн хөгжил нь Ази төдийгүй дэлхийн энх тайван, тогтвортой байдалд хувь нэмрээ оруулна, цаашилбал 2-рт Монгол улс Япон улстай найрамдалт түншийн харилцаатай орон болно гэдэгт найдаж Монгол улсад үзүүлэх зээл тусламжийн хүрээгээ өргөжүүлсэн билээ. Үүний зэрэгцээ, олон улсын нийгэмлэгийн хүрээнд “Монгол улсад хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулахыг уриалж, ажил хэрэг болгон Япон улс нь Монгол улсын хандивлагч орнууд дотор голлох үүргийг гүйцэтгэсээр ирсэн.

Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр” нь Хөгжлийн албан ёсны тусламжийн нэг хэсэг бөгөөд тухайн орон нутгийн шаардлагад нийцсэн, ард иргэдэд ашиг тусаа шууд өгөхүйц жижиг хэмжээний төслүүдийг дэмждэгээрээ онцлог юм.

“ӨВСНИЙ ҮНДЭС” ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Япон улсын Засгийн газраас хөгжиж буй орнуудын олон талын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор санхүүгийн тусламжийн хөтөлбөрийг санал болгож байна. “Өвсний Үндэс – Хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр” нэртэй энэхүү хөтөлбөр нь Засгийн газрын бус байгууллага, орон нутгийн засаг захиргаа зэрэг ашгийн бус байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслүүдийг дэмжих зорилготой юм. Жижиг хэмжээний хөгжүүлэх төслүүдэд уян хатан, цаг үеэ олсон дэмжлэг туслалцаа үзүүлдэгээрээ “Өвсний Үндэс” хөтөлбөр нь олон түмэнд танигдсан билээ.

Энэхүү танилцуулга нь тус хөтөлбөрийн зорилго, журам болон хөтөлбөрийн хүрээнд тусламж авахад шаардагдах бусад зүйлийн талаар өгүүлнэ.

ЗОРИЛГО

“Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага, эрүүл мэнд, боловсролын байгууллага зэрэг ашгийн бус байгууллагуудад жижиг хэмжээний хөгжлийн төсөл хэрэгжүүлэхэд нь санхүүгийн тусламж үзүүлдэг болно.

Тухайн оронд “Өвсний үндэс” хөтөлбөрийн дагуу санхүүжилт хийх болсноор Японы засгийн газрын Хөгжлийн Албан Ёсны Тусламж нь өргөн олон түмний амьжиргаанд шууд нөлөөлөхүйц хамтын ажиллагааны шинэ агуулгаар баяждаг билээ.

ТУСЛАМЖ АВАХ БАЙГУУЛЛАГА

Уг тусламжийг ашгийн бус аль ч байгууллага авах эрхтэй. Тавигдах гол шаардлага бол тус ашгийн бус байгууллага нь тухайн оронд өргөн олон түмнийг хамарсан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төсөл хэрэгжүүлж байхад оршино. (Хувь хүн ба ашгийн аливаа байгууллага үүнд хамаарахгүй.)

Тусламжийг авах эрх бүхий байгууллагуудаас дурдвал олон улсын болон орон нутгийн Засгийн газрын бус байгууллагууд (ажилтны яс үндсийг харгалзахгүй боловч, Японы ТББ-уудад үзүүлэх буцалтгүй тусламжийн хүлээн авагчид хамаарахгүй), орон нутгийн засаг захиргааны нэгж, эрүүл мэнд, боловсролын байгууллага зэрэг ашгийн бус байгууллагууд болно. Онцгой тохиолдолд Засгийн газрын харъяа байгууллага, олон улсын байгууллага хүлээн авагч байж болно.

ХАМРАХ ХҮРЭЭ

1. Тухайн нийгэм, эдийн засгийн хөгжлийн төсөл нь жижиг хэмжээтэй тохиолдолд “Өвсний үндэс” хөтөлбөрт хамрагдан тусламж авах эрхтэй болно. Монгол улсын хувьд доорх салбаруудад онцгой анхаарал хандуулна. Үүнд:

- Эрүүл мэндийг хамгаалах (анхан шатны);
- Ерөнхий боловсрол;
- Ядуурлыг бууруулах;
- Олон нийтийн аж ахуйг сайжруулах;
- Байгаль орчин зэрэг орно.

Болзлыг хангах төслүүдийн заримаас жишээ болгон дурдвал:

- Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг засварлах ба тоног төхөөрөмж нийлүүлэх;
- Эмнэлгийн барилгыг засварлах ба эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх;
- Худаг гаргах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн сургалт явуулах;
- Эмэгтэйчүүдийг чадваржуулах мэргэжлийн сургалтанд хамруулах;
- Ашиглагдаж байсан гал унтраах болон түргэн тусламжийн машин, унадаг дугуй, ширээ сандал нийлүүлэх тээврийн зардал;
- Газарт булагдсан тэсрэх бодисыг аюулгүйжүүлэх, хохирогчдод тусламж үзүүлэх, тэсрэх бодисноос сэргийлэх сургалт явуулах;
- Бичил зээлийн үйл ажиллагаа зэрэг болно.

2. Нэн тэргүүнд тусламж үзүүлэх салбаруудыг тухайн орны хөгжлийн эрэлт хэрэгцээг харгалзан тухайн улсад суугаа Япон улсын ЭСЯ тодорхойлно.

ТУСЛАМЖИЙН САН

“Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх тусламжийн хөрөнгийн асуудлыг ирсэн хүсэлт бүрийг шалган үнэлгээ гаргасны эцэст шийдвэрлэнэ.

Үндсэндээ нэг төсөлд ноогдох тусламжийн хэмжээ 10 сая иенээс хэтрэхгүй байна.

Дараах зүйлүүдэд санхүүгийн тусламж үзүүлэхгүй гэдгийг хүсэлт гаргаж буй байгууллагууд анхаарвал зохино. Үүнд: сэлбэг хэрэгсэл (хүмүүнлэгийн буюу яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд), барилга байгууламж буюу тоног төхөөрөмжийн урсгал зардал, хүлээн авагч байгууллагын удирдлага, үйл ажиллагаатай холбоотой бусад урсгал зардлууд багтана.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

“Өвсний үндэс” хөтөлбөр нь Монгол улсад 1990 онд анхны төслөө хэрэгжүүлж эхэлснээс хойш нийт хэрэгжүүлсэн төслийн тоо 2016 оны 8 дугаар сарын 16-нд 500-д хүрч, тусламжийн нийт дүн 33,586,674 ам.долларт хүрлээ.

Уг хөтөлбөр нь Монгол улсын бүх аймагт хэрэгжсэн ба нийт 332 сумаас 206 сумдад хэрэгжээд байна. Цаашид үлдсэн бүх сумдад тусламжийн гараа сунган ажиллах болно.

ХҮСЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

Хэрэв танай байгууллага, дээр дурдсан нөхцөлүүдийг хангаж хөгжлийн төсөл хэрэгжүүлэхдээ “Өвсний үндэс” хөтөлбөрийн санхүүгийн тусламж авахыг хүсвэл Япон улсын ЭСЯ-нд хандаарай.

Хаяг, холбоо барих утас:

Улаанбаатар хот 14210, Элчингийн гудамж 10,

Төв шуудан ш/х 1011, Монгол улс

ЯПОН УЛСЫН ЭСЯ

“Өвсний үндэс” хөтөлбөр хариуцсан ажилтантай холбоо барих

Утас : 976-11-320777, 976-70000776

Факс : 976-11-313332

Вэб : www.mn.emb-japan.go.jp

ХЭРЭГЖСЭН ТӨСЛҮҮДИЙН СТАТИСТИК ТООН ҮЗҮҮЛЭЛТ


АЙМАГ, НИЙСЛЭЛ ТУС БҮРЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ТОО БОЛОН НИЙТ ТӨСВИЙН ХЭМЖЭЭ 1990-2016.08

	Аймаг, нийслэл	Төслийн тоо	Нийт төсвийн хэмжээ (ам.доллар)
1	Улаанбаатар	129	7,886,654
2	Архангай	16	1,089,021
3	Баян-Өлгий	18	1,078,740
4	Баянхонгор	20	1,206,774
5	Булган	16	975,806
6	Говь-Алтай	16	1,140,366
7	Говьсүмбэр	8	519,109
8	Дархан-Уул	19	1,589,707
9	Дорноговь	15	1,061,335
10	Дорнод	24	1,506,619
11	Дундговь	12	766,454
12	Завхан	16	1,126,507
13	Орхон	9	743,517
14	Өвөрхангай	17	1,163,149
15	Өмнөговь	13	719,109
16	Сүхбаатар	11	733,677
17	Сэлэнгэ	22	1,731,506
18	Төв	19	1,322,152
19	Увс	26	1,825,358
20	Ховд	18	1,387,734
21	Хөвсгөл	24	1,546,599
22	Хэнтий	18	1,423,047
23	Бусад	14	1,043,734
	Нийт	500	33,586,674


ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН САЛБАР БОЛОН НИЙТ ТӨСВИЙН ХЭМЖЭЭ 1990-2016.08

Салбар	Төслийн хэмжээ		Төсвийн хэмжээ	
	тоогоор	хувиар	ам.доллараар	хувиар
Боловсрол	321	64.20%	23,312,250	69.41%
Эрүүл мэнд	104	20.80%	5,871,506	17.48%
Нийтийн аж ахуй	43	8.60%	2,403,039	7.15%
Хөдөө аж ахуй	4	0.80%	187,133	0.56%
Тээвэр, холбоо	3	0.60%	220,545	0.66%
Бусад	25	5.00%	1,592,201	4.74%
Нийт	500	100%	33,586,674	100%

“ӨВСНИЙ ҮНДЭС” ХӨТӨЛБӨРИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭНД НИЙСЛЭЛ БОЛОН ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ХУВЬ 1990-2016.08




“ӨВСНИЙ ҮНДЭС” ХӨТӨЛБӨРИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ (АЙМАГ, НИЙСЛЭЛ ТУС БҮРЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ТОО)




“ӨВСНИЙ ҮНДЭС” ХӨТӨЛБӨРИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ (САЛБАР ТУС БҮРЭЭР)




БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХЭРЭГЖСЭН ТӨСЛИЙН ТОО, ТӨРЛӨӨР



8



Улаанбаатар
129 төсөл



ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС

Улаанбаатар хотын нэгдсэн 3-р эмнэлэгт эмнэлгийн зориулалттай ор тээвэрлэх төсөл (2007 он, №311)



Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан өвчтөнүүд энгийн ор ашиглаж байсан. Бие даан хөдлөх боломжгүй өвчтөнд энэ төрлийн ор тохиромжгүй байсан тул эмчилгээнд тохирсон 200 ширхэг эмнэлгийн зориулалттай ор нийлүүлсэнээр иргэдийн хэвтэн эмчлүүлэх орчин сайжирсан юм.

Увс аймгийн Улаангом сумын 1-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн төсөл (2007 он, №303)



Өргөтгөл хэсэг



Увс аймгийн Улаангом суманд цэцэрлэг дутагдаж байсан тул, Өвсний Үндэс хөтөлбөрөөр өргөтгөл барин 5-6 настай 71 хүүхэд цэцэрлэгт нэмж хамрагдах боломжтой болсноор, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байсан хүүхдүүдийн тоо цөөрсөн юм.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС

Ховд аймгийн Дуут сумын 11 жилийн сургуулийн дотуур байрны засварын төсөл (2008 он, №327)



Дотуур байранд засвар хийснээр орон тоо 40%-иар нэмэгдэж, дотуур байранд орж чадалгүй сургууль завсардсан хүүхдүүдийг хүлээн авах боломж бүрдсэн юм.

Улаанбаатар хот дахь Гэмтэл согог судлалын үндэсний төвд түргэн тусламжийн машин тээвэрлэх төсөл (2008 он, №317)



Тухайн үед эмнэлэг түргэн тусламжийн машингүй байсан бөгөөд түргэн тусламжийн үйлчилгээнд энгийн автомашин ашигладаг байсан. Буцалтгүй тусламжаар ашиглагдаж байсан түргэн тусламжийн 6 машин нийлүүлсэнээр өвчтөний биед үзүүлэх ачаалал эрс багассан.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС


Баянхонгор аймгийн Баянхонгор сумын
Соого-Сейко сургуулийн өргөтгөлийн төсөл
(2009 он, №352)



Японы Ооита мужийн Соого-Сейко сургуультай хамтран хичээлийн байрны өргөтгөл хийснээр 12 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэл ажлын хүрээнд жил бүр 160 сурагч хүлээн авч сургах боломж бүрдсэн.



Баянхонгор аймгийн Бууцагаан сумын хүн эмнэлгийн
засварын төсөл (2009 он, №340)



Ашиглагдахгүй байсан эмнэлгийн барилгыг зассанаар, үзлэг болон шинжилгээний өрөөний хүрэлцээгүй байдал арилсан. Үүний үр дүнд, аймгийн төвийн нэгдсэн эмнэлэгт үзүүлээд ирэхэд 300 гаруй км туулдаг байсан өвчтөнүүдийн ачаалал багасч, физик эмчилгээний өрөө ашиглалтад орсноор өндөр настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээ сайжирсан зэрэг үр дүн гарсан.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС

Сэлэнгэ аймгийн Ерөө суманд Хүүхдийн экологийн зуслан барих төсөл (2009 он, №355)



Ерөө сум, Бугант тосгоны сургуулийн сурагчидад байгаль орчны тухай мэдлэг боловсролоо гүнзгийрүүлэхэд нь зориулан энэхүү зусланг барьсан юм. Япон улсын Засгийн газар нь энэ мэт байгал орчны асуудлыг шийдвэрлэхтэй уялдуулан олон үйл ажиллагааг Монгол улсад хэрэгжүүлж байгаа юм.



Яаралтай тусламж (Зуданд нэрвэгдсэн ард иргэдэд туслах төсөл)

2000 онд

- Монголын зудын хохиролыг бууруулах яаралтай нэгдсэн төлөвлөгөөний төсөл (№117)
- Монгол улсад яаралтай тусламжийн хүнс тээвэрлэх төсөл (№118)
- Монгол улсад хүнсний яаралтай тусламж үзүүлэх төсөл (№119)

2009 онд

- Говь-Алтай болон бусад 5-н аймгийн зуданд нэрвэгдсэн ард иргэдэд туслах төсөл (№356)
- Архангай болон бусад 5-н аймгийн зуданд нэрвэгдсэн ард иргэдэд туслах төсөл (№357)



“Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хүрээнд тулгамдсан асуудлуудыг шуурхай шийдвэрлэх үүднээс зуданд нэрвэгдсэн ард иргэдэд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх зэргээр яаралтай тусламжуудыг үзүүлж ирсэн юм.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС

Говь-сүмбэр аймгийн 3 сумын усан хангамжийг сайжруулах төсөл (2010 он, №360)



Монголын ард түмний амьдрал, эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйл бол ус юм. Энэхүү төслөөр худаг шинээр барьж, засан засварласнаар Говьсүмбэр аймгийн 3 сумын 2,500 малчид, иргэдийг ундны усаар тогтмол хангаж, орон нутгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан юм.


Увс аймгийн Тариалан сумын 11 жилийн сургуулийн засварын төсөл (2011 он, №392)



1971 онд баригдсан сургуулийн барилгын засвар. Хуучирч муудсан хичээлийн байрны дээврээс ус гоождог, ханын будаг, шавардлага хууларч муудсан, цонх, шал нь үжиршсэн байсныг засварласнаар хүүхдийн сургалтын орчин сайжирч, тохиллог орчин бүрдсэн.





ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС

Завхан аймгийн Цагаанхайрхан сумын сургуулийн их засварын төсөл (2012 он, №409)



1974 онд ашиглалтанд орсон хичээлийн байр нь нэг ч удаа их засвар хийгдээгүйгээс хуучирч муудаад байсныг тус төслөөр засварласнаар 170 гаруй сурагчдын сургалтын нөхцөл сайжирч эрүүл мэндийн шаардлага хангасан тав тухтай орчин бүрдсэн юм.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 34-р сургуулийн их засварын төсөл (2013 он, №423)




Тус төслөөр дотор засал, цахилгаан, цэвэр бохирын шугамыг засварласнаар эрүүл ахуйн шаардлага хангасан тав тухтай орчинд 1000 орчим хүүхэд хичээллэх нөхцөл бүрдсэн.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС

Дорнод аймгийн Хэрлэн сумын 2-р сургуулийн дотуур байр барих төсөл (2013 он, №428)







Монголд хөдөө орон нутгийн хүүхдүүд сургуульд явахын тулд ихэвчлэн дотуур байранд байрладаг тул тус сургуульд дотуур байр зайлшгүй шаардлагатай байсан ба уг төслөөр шинэ дотуур байр барьснаар 30 орчим хүүхэд эрүүл аюулгүй орчинд амьдран, сурч боловсрох нөхцөл бүрдсэн юм.



Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн засварын төсөл (2014 он, №449)





Тус төв нь эрүүл мэндийн үзлэг эмчилгээнээс гадна дотроо гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид (эмэгтэйчүүд)-д үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээ”-г байгуулан үйл ажиллагаа явуулж буй билээ. Тус төвд их засвар хийснээр, хонож үйлчлүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг шаардлагатай тохиолдолд хамгаалалтандаа авах боломжтой болсон.





ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУДЫН ФОТО ЗУРГУУДААС

Баянхонгор аймагт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үйлчилгээний байр барих төсөл (2014 он, №460)



Япон улсын Засгийн газар нь олон төрөл хэлбэрээр орон нутагт эрүүл, аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэхэд тусламж үзүүлж ирсэн ба тус төслөөр Баянхонгор аймагт “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төв”-ийг шинээр барьж байгуулснаар гэр бүл, ахуйн хүрээнд гарч байгаа хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын
1-р цэцэрлэгийн засварын төсөл (2015 он, №471)



Тус цэцэрлэгийг засварласнаар 430 орчим хүүхдийн сургалтын нөхцөл сайжирсан бөгөөд уг төсөл хэрэгжсэнээр аймгийн нэгдсэн эмнэлэгт үзүүлсэн тусламжтай нийлээд Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд хэрэгжсэн 2 дахь төсөл болсон юм.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛАРХЛЫН ҮГС



Төсөл хэрэгжсэн сургуулиудын сурагчдаас ирүүлсэн захидлууд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12-р цэцэрлэгийн хамт олноос (2008 онд хэрэгжсэн төсөл, №325)

Та бүхний засаж, сэргээн засварласан энэ сайхан цэцэрлэгийн хамт олон бид:

2009 онд “Аймгийн тэргүүний цэцэрлэг”,

2011 онд Аймгийн засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн “Хүүхдэд ээлтэй байгууллага”

2011 онд БСШУ Байгууллагуудын “Хүүхдийн төлөө сайн үйлстэн байгууллага”-аар шалгарч амжилт бүтээлээр дүүрэн ажиллаж байна.

Энэ бүх амжилтанд хүрэхэд та бүхний хүмүүнлэг энэрэнгүй тусламжийн ажил бодитой хувь нэмрийг оруулсанд гүнээ талархаж байна.



Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 11 жилийн дунд сургуулийн 11-р ангийн сурагчдаас (2006 онд хэрэгжсэн төсөл, №263)

Манай сумын сургууль халаалт байхгүй байхад түлээ бэлдэж пийшин галлаж хичээл дээрээ зузаан дээл, куртиктэй хичээлдээ суудаг байсан. Байрны хүүхдүүд хувцастайгаа шахуу унтаж хөдөөний зарим хүүхдүүд гэрлүүгээ оргож байрын багш нь тэдний хойноос явах тохиолдол гардаг байсан. Харин одоо дотуур байр халаалттай болсноор даарах гэдгийг мартан тохь тухтай унтаж амардаг боллоо. Спорт залгүй байхад гадаа гүйж нэг жижигхэн өрөөнд барилдаж ноцолдож биеийн тамирын хичээл ордог байсан. Ийм бэрхшээлийг “Өвсний үндэс” хөтөлбөрийн төсөл, санхүүжилтээр 2007, 2010 онд бүрэн шийдвэрлэсэн. Одоо спорт залтай болсноор тохьтой дулаан орчинд хичээл орж бэлтгэл дасгал хийж амжилт гаргаж байна. Спорт залтай болоод нэг жилийн дараа аймгаас медаль авч хоёр жил болоход улсаас алт, мөнгөн медаль, хөнгөн атлетикийн УАШ-х тэмцээнээс мөнгө хүрэл, Олон улсын хөнгөн атлетикийн тэмцээнээс мөнгөн медаль авч амжилтаа ахиулсаар байгаа нь спорт залтай болсны үр дүн юм. Ёстой л нүдээ олсон тусламж болсонд Японы ард түмэн болон Засгийн Газар, “Өвсний үндэс” хөтөлбөрт талархаж байгаагаа илэрхийлж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Та бүхнийг бидэнд дахин туслаж, Японы хүүхдүүдтэй найз нөхөд болохыг хүсэж байна.



Улаанбаатар хотын Нэгдсэн 3-р эмнэлгийн хамт олноос (2007 онд хэрэгжсэн төсөл, №311)

Тус эмнэлэгт Япон улсын засгийн газрын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд 2008 оны 10-р сарын 1-ний өдөр буцалтгүй тусламжаар өгсөн эмнэлгийн зориулалт бүхий 200 орыг ашигласнаар Зүрх судас, Тархи нуруу нугасны мэс засал болон дотрын тасгийн үйлчлүүлэгч нарын эмчилгээнд эерэг нөлөө үзүүлсэнд эмчлүүлэгч болон эмнэлгийн эмч, сувилагч ажилчид баярлаж байдаг юм.

Мөн эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчийн тоо 2008 онтой харьцуулахад 2011 онд 2213-аар нэмэгдсэн нь уг төслийн үр дүн юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн 12 жилийн дунд сургуулийн хамт олноос (2010 онд хэрэгжсэн төсөл, №361)



Монгол улсын ирээдүй болсон хүүхэд багачуудын маань сурч, хөгжих таатай орчин бүрдүүлэхэд халуун сэтгэлийн тусламж дэмжлэг үзүүлэн чанартай хөрөнгө оруулалт хийсэн нь манай сургуулийн багш, сурагч, эцэг эхчүүдийн гүнээ талархалыг хүлээж байгааг хүргэхэд таатай байна. Та бүхний хүүхдийн төлөө хийж буй буянт ажилд өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе.

Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хамт олонд

Намайг Номин-Эрдэнэ гэдэг. Би 5а ангид сурдаг. Бид нар өмнө нь хичээл хийхэд хүйтэн, тухгүй, самбар дээрх юм харагддаггүй байсан. Одоо байгаа орчин маань бидний сурах эрмэлзлэлийг нэмэгдүүлж, дулаахан тохилог орчныг бүрдүүлж өгсөнд би та бүхэндээ маш их баярлаж байна. Бид болон бидний дүү нарыг маань эрдэм ном сургаж мөрөөдөлд нь нэг алхам ч гэсэн түлхэж өгсөн та бүхэндээ баярлалаа.

5а ангийн сурагч: О. Номин-Эрдэнэ

Өвөрхангай аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн хамт олноос (2009 онд хэрэгжсэн төсөл, №336)

Манай сургуулийн дотуур байр 1977 онд ашиглалтанд орсон бөгөөд ашиглалтын явцад болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр дээвэр хэсэгчилэн хуулан, үүний улмаас цахилгааны монтажид гэмтэл үүссэн, хана тааз нурсан, хаалга цонхонд гажиг үүссэн зэрэг засвар зайлшгүй хийх хэрэгцээ шаардлага байсан. Энэ үед буюу 2009 онд бидэнд тусламжийн гараа сунгаж, дотуур байрыг засварлан малчдын хүүхдийн эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсанд гүнээ талархаж байна.

“Дотуур байр – Миний гэр”

Намайг Өнөрмаа гэдэг. Сумынхаа дотуур байрны төрсөн охин нь гэхэд бараг л хилсдэхгүй. Яагаад гэхээр төрсөн гэртээ 6 жил, дотуур байрандаа 11 жил амьдарч байна даа. Хөдөөнөөс ирж сургуулийн босго алхахдаа энэ дотуур байранд амьдрах болж, байртайгаа дасал болох гэж нилээд юм болдог байлаа. Харин “Өвсний үндэс” хөтөлбөрийн ах, эгч нар маань бидний байрыг баячуудын амьдардаг хаус шиг л болгож өгсөн. Бидэнд тусалсан та бүхэндээ маш их баярлалаа.

11а ангийн сурагч: Э.Өнөрмаа

**Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын С.Дашдооровын нэрэмжит
ЕББД сургуулийн хамт олноос
(2004 онд хэрэгжсэн төсөл, №214)**



Манай сургууль нь 1992 онд анх байгуулагдсан. Анх манай сургуульд 1994 онд Япон улсын иргэн Фусака ирж Японы зан заншилын танхим байгуулж байсан.

Японы элчин сайдын яамны “Өвсний

үндэс” хөтөлбөрөөр 1997 онд сургуулийн хоёр ангийн гэрэлтүүлэг, 2004 онд сургуулийн 1-р байранд засвар хийсэн нь сурагчдын сурч хөгжих таатай орчин бүрдэж одоо 436 суралцагч 69 багш ажилчидтай сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Бидний хойч ирээдүйн мэдлэг боловсрол олж авах таатай орчинг бүрдүүлж өгсөн “Өвсний үндэс” хөтөлбөрийн хамт олонд баярлаж талархсанаа Дэлгэрхангай сумын сургуулийн багш ажилчид, суралцагч, иргэдийн зүгээс илэрхийлж байна.



**Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р цэцэрлэгийн хамт олноос
(2009 онд хэрэгжсэн төсөл, №342)**



Японы Элчин сайдын яамны Өвсний үндэс хөтөлбөрөөр цэцэрлэгийн орчин нөхцөл сайжирсанаар эцэг эхчүүдийн сургуулийн өмнөх боловсролыг хүүхдэдээ эзэмшүүлэх хандлага, цэцэрлэгт итгэх итгэл, сэтгэл ханамж, үнэлэмж өөрчлөгдөж цэцэрлэгт хамрагдалт нэмэгдэж



байна. Багш ажиллагсад маань СӨБ-ын үйлчилгээг хүүхдэд чанартай сайн үзүүлэх, өнөөгийн хүүхдийн хөгжлийн онцлог, стандартад нийцсэн орчинд ажиллах бололцоогоор хангагдсандаа талархаж байна.

**Баянхонгор аймгийн Бууцагаан сумын эрүүл мэндийн
төвийн хамт олноос
(2009 онд хэрэгжсэн төсөл, №340)**



Баянхонгор аймгийн Бууцагаан сумын “Эрүүл мэндийн төв” нь 1938 онд байгуулагдсан. Эрүүл мэндийн төвийн эмч ажиллагсадын ажиллах өрөө байрны багтаамж муу, цөөн өрөө тасалгаатай нэг өрөөнд 3-4 эмч сууж иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг нь бэрхшээлтэй байсан тул хуучин эмнэлгийн барилгыг ашиглах зайлшгүй шаардлагатай байсан. Иймд 2009 онд Японы Засгийн газрын “Өвсний үндэс” төслийн санхүүжилтээр их засвар хийгдсэн нь орон нутгийн болон бүсийн хэмжээний эрүүл мэндийн салбарт тулгамдаж байсан

томоохон асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдол өгсөн билээ. Амбулаторийн тусламж үйлчилгээг 2010-2011 онд бүсийн 4 сумын 12000 орчим хүн амд үзүүлж, лабораторийн тусламж үйлчилгээг 5944 хүнд үзүүлсэн нь иргэдийн аймаг хот руу явах зардал чирэгдлийг багасгасан тэгш хүртээмжтэй үйлчилгээ болж байгаад бүсийн сумын ард иргэд сэтгэл хангалуун байна. “Өвсний үндэс” хөтөлбөрийн хамт олонд талархсанаа илэрхийлж байна.

Харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн хамт олноос (2008 онд хэрэгжсэн төсөл, №319)



Монгол дахь Японы ЭСЯ-ны “Өвсний үндэс” хөтөлбөрт Манай төслийг дэмжин харааны бэрхшээлтэй хүүхдийн амьдрах, суралцах орчинг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулсанд гүнээ талархаж байна.



Увс аймгийн Улаангом сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн хамт олноос (2007 онд хэрэгжсэн төсөл, №303)



Улаангом сумын 1-р цэцэрлэг нь 1958 онд байгуулагдаж, 54 дэхь жилдээ сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулж байна. Стандартын бус байранд сургалтын үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд тойргийн хүүхдүүдийн 60%-ийг хамруулан ажиллаж байсан. 2008 онд 50 хүүхдийн цэцэрлэгийн байртай болсноор хүүхэд хүлээн авах хүчин чадал 96%-д хүрч, хүүхдийн хамрагдалтын индекс 36%-иар өсөж, тохилог тав тухтай орчинд сурч хөгжих боломж бүрдсэн. 50 хэмийн хүйтэнд гадна бие засдаг, тохилог орчингүй байсан бидэнд дулаан, тохилог, цэвэр, эрүүл

орчин бэлэглэсэн төслийн хамт олонд туйлын баярлаж явдагаа илэрхийлье.

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын ахлах сургуулийн хамт олноос (2006 онд хэрэгжсэн төсөл, №271)



2006 онд бидний хүсэлтийг хүлээн авч манай сумын 10 жилийн дунд сургуулийн дотуур байрыг засварлан тохижуулахад 40 мянган ам.долларын хөрөнгө оруулалт хийж төвөөс алслагдсан малчдын хүүхдийг ая тухтай орчинд амьдарч, сурч боловсрох боломжийг бүрдүүлсэнээс гадна малчдын хүүхдийн сургуульд суралцах идэвхи өрнөж, 2007 оноос эхэлж хүүхдийн сургууль завсардалт эрс багасав. Дотуур байрны хүүхдийн сургалтын чанар сайжирсанд танай газрын дэмжлэг туслалцаа сайнаар нөлөөлснийг тэмдэглэж баярлаж талархсанаа илэрхийлж, Та нөхдийн цаашдын ажлын амжилт, амьдралд тань аз жаргалтай

байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж хорвоогийн хамгийн сайн сайхан бүхнийг хүсэж байна.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн хамт олноос (2005 онд хэрэгжсэн төсөл, №259)

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлд Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн санхүүжилтээр 2006 онд Оношлогоо шинжилгээний төвийн барилга, Хүүхдийн түргэн тусламжийн станцид яаралтай тусламж үзүүлэх иж бүрэн тоноглол бүхий автомашин, 2010 онд Салбар амбулатори 1-ийн өргөтгөл-Эмийн бус эмчилгээний цогцолборын барилгыг бариулж өгсөнд манай хамт олон төдийгүй дүүргийн иргэд гүнээ талархаж байдаг билээ.

2006-2011 онуудад Оношлогоо шинжилгээний төвөөр давхардсан тоогоор 189,000 гаруй үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна. Оношлогоо шинжилгээний төвийг байгуулснаар иргэд оношлогоо, шинжилгээний тусламж үйлчилгээг нэг цэгээс авах боломж бүрдэн, үйлчлүүлэгчдийн чирэгдэл хүлээгдэл буурсан.

Мөн 2006 онд Япон улсад үйлдвэрлэсэн Тоёото Химедик маркийн түргэн тусламжийн автошиныг бэлэглэснээр дүүргийн 16 хүртэлх насны хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх боломж бүрдсэн. Уг автомашинаар нийт 78,524 хүүхдэд яаралтай тусламжийг үзүүлээд байна.

2010 онд ЭМН-ийн Салбар амбулатори 1-ийн барилгын зүүн хэсгийг 3 давхар болгон өргөтгөн, Эмийн бус эмчилгээний цогцолборыг байгуулж, сургалтын танхим, чийрэгжүүлэлт, уламжлалт болон нөхөн сэргээх эмчилгээний кабинетуудыг байршуулан нэг цэгийн үйлчилгээг бий болгосноор, Эмийн бус эмчилгээний кабинетуудаар үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, орчин нөхцөл сайжирсан.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамт олноос (2014 онд хэрэгжсэн төсөл, №460)



**NATIONAL CENTER
AGAINST VIOLENCE**
Chingeltei District, Ulaanbaatar,
Baga Toiruu-40 House Apartment#3
Tel/Fax: 976-70119949,
E-mail: mongolcav@mongol.net
Website: www.safefuture.mn
Date: 21 June, 2016

To Grant Assistance for Grassroots
Project, Embassy of Japan

National Center Against Violence (NCAV) was founded in 1995. Since then, NCAV has been operating to combat domestic violence against women and children in Mongolia. Nationally, NCAV runs 16 branch offices and 3 shelters. NCAV implements its strategies through 6 programs and combines direct services and policy advocacy.

As a result of many years of law advocacy of NCAV, a new comprehensive legal system that consists of Law to Combat Domestic Violence and other related laws on victim protection: Criminal Code, Law on Investigation of Criminal Offences, Petty Offence Code, Code on Law Enforcement Proceedings and Court Execution Law has been created.

Under this legislative reform, One Stop Crisis Center to provide protection to victims is legislated for the first time.

NCAV is expressing its sincere appreciation to Grant Assistance for Grassroots Project, Embassy of Japan, for its great contribution in building of One Stop Crisis Center to develop victim protection services in line with international standards.

Please see the attached report to get detailed information on construction process of One Stop Crisis Center.

May our partnership for human safety and peace strengthen more in future.

Sincerely,



Director

D.Enkhjargal

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргаас (2014 онд хэрэгжсэн төсөл, №462)



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ШАРЫН ГОЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**
45010 Шарын гол сум, Дархан-Уул аймаг
Утас: 7037-2521
E-mail: sharyngol_zhd@yahoo.com

ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА
ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД
ТАКЭНОРИ ШИМИЗУ ТАНАА

АХС. 01. 27 № 01/57
танил -ны №

Танд энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Монгол, Япон Улсын найрамдал хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монгол Улсын боловсролын салбарыг хөгжүүлэх тэр дундаа манай сумын хүүхдүүдийн сурах орчин нөхцлийг сайжруулах, орчин үеийн сургалтын чанарыг хүртэх нөхцөл бололцоог бүрдүүлж буй үйлсэд нь миний бие туйлын их баяртай байна.

Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд Шарын гол суманд хэрэгжүүлсэн 2 төсөл амжилттай хэрэгжиж тус сумын 8000 гаруй иргэдэд үр өгөөжөө өгч нийгмийн боловсрол, хүүхдүүдийн сурах орчин нөхцөл боловсролын чанарт ахиц, дэвшил гарч байгаад Элчин сайд танд болон Япон Улсын ард түмэн, Япон Улсын Элчин сайдын яамны хамт олонд талархаж байгаагаа илэрхийлье.

Япон Улсын Элчин сайдын яамтай хамтран ажилладагтаа үргэлж таатай байдагаа илэрхийлж, цаашдын хамтын ажиллагаа улам гүнзгийрч үргэлжилнэ гэдэгт миний бие итгэлтэй байна.

Япон Улсын Элчин сайдын яамны хамт олонд болон сайд танд эрүүл энх, аз жаргал, ажлын амжилт хүсье.

ЗАСАГ ДАРГА



Д.АМАРСАНАА

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

№	Он	Хэрэгжсэн газар	Төслийн нэр	Мөнгөн дүн /ам.доллар/
1	1990	Улаанбаатар	В гепатитийн эсрэг вакцин үйлдвэрлэх технологийг сайжруулах төсөл	39,047
2	1990	Улаанбаатар	Хувийн хэвшлийн тусламжийн барааг тээвэрлэх төсөл	11,584
3	1991	Улаанбаатар	Хувийн хэвшлийн тусламжийн барааг тээвэрлэх төсөл	4,515
4	1991	Улаанбаатар	Геодези болон газрын зураг боловсруулах технологийн чадавхийг сайжруулах төсөл	37,032
5	1991	Улаанбаатар	В гепатитийн эсрэг вакцин үйлдвэрлэх технологийг сайжруулах төсөл	34,049
6	1992	Улаанбаатар	Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжих төсөл	30,600
7	1992	Улаанбаатар	Хувийн хэвшлийн тусламжийн барааг тээвэрлэх төсөл	9,182
8	1992	Улаанбаатар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нөхөн сэргээх тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	37,820
9	1993	Улаанбаатар	Номын сан болон мэдээллийн төвийн тохижилтын төсөл	39,214
10	1993	Улаанбаатар	Хувийн хэвшлийн тусламжийн барааг тээвэрлэх төсөл	12,562
11	1993	Улаанбаатар	Эмэгтэйчүүдийн холбоо хувийн хэвшлийн тусламжийн барааг тээвэрлэх төсөл	9,564
12	1993	Улаанбаатар	Радио нэвтрүүлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	37,872
13	1994	Дорнод	Дорнод аймгийн соёлын үйлчилгээг сайжруулах төсөл	36,163
14	1994	Төв	Төв аймгийн соёлын үйлчилгээг сайжруулах төсөл	36,163
15	1994	Өвөрхангай	Өвөрхангай аймгийн соёлын үйлчилгээг сайжруулах төсөл	36,163
16	1994	Баянхонгор	Баянхонгор аймгийн соёлын үйлчилгээг сайжруулах төсөл	36,163
17	1994	Өвөрхангай	Өвөрхангай аймгийн Хужирт сумын соёлын үйлчилгээг сайжруулах төсөл	36,163
18	1994	Өмнөговь	Өмнөговь аймгийн соёлын үйлчилгээг сайжруулах төсөл	36,163
19	1994	Улаанбаатар	Хувийн хэвшлийн тусламжийн барааг тээвэрлэх төсөл	11,138
20	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 86-р сургуулийн хөдөлмөр сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,220
21	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 56-р сургуулийн хөдөлмөр сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,220
22	1995	Дорноговь	Дорноговь аймгийн сургуулийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	29,937
23	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 40-р сургуулийн хөдөлмөр сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,360
24	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 67-р сургуулийн хөдөлмөр сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,360
25	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 41-р сургуулийн хөдөлмөр сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,360
26	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 17-р сургуулийн мэргэжлийн сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,360
27	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 16-р сургуулийн мэргэжлийн сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,220
28	1995	Улаанбаатар	Улаанбаатар хотын 21-р сургуулийн хөдөлмөр сургалт олгох тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл	30,220
29	1996	Улаанбаатар	Монголын үндэсний телевизийн өсвөр үеийнхэнд зориулсан танин мэдэхүйн нэвтрүүлгийг дэмжих төсөл	19,190
30	1996	Улаанбаатар	29-р сургуулийн дотуур байрны их засварын төсөл	64,911

31	1996	Улаанбаатар	Эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн боловсрол олгох тоног төхөөрөмж сайжруулах төсөл	23,710
32	1996	Улаанбаатар	Ахлах сургуулийн хөдөлмөр сургалтыг сайжруулах төсөл	33,723
33	1996	Улаанбаатар	Улсын нэгдсэн 3-р эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлэх төсөл	89,720
34	1996	Архангай	Архангай аймгийн Тариат сумын дунд сургуульд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх төсөл	17,647
35	1996	Төв	Төв аймгийн Баян-Өнжүүл сумын дунд сургуульд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх төсөл	17,647
36	1996	Дундговь	Дундговь аймгийн Хулд сумын дунд сургуульд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх төсөл	17,647
37	1996	Баянхонгор	Баянхонгор аймгийн Галуут сумын дунд сургуульд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх төсөл	17,647
38	1996	Архангай	Архангай аймгийн Хотонт сумын төрөх эмнэлэг барих төсөл	21,793
39	1996	Баянхонгор	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын төрөх эмнэлэг барих төсөл	22,090
40	1996	Булган	Булган аймгийн Хангал сумын төрөх эмнэлэг барих төсөл	21,627
41	1996	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн Жаргалант сумын төрөх эмнэлэг барих төсөл	21,826
42	1996	Завхан	Завхан аймгийн Асгат сумын төрөх эмнэлэг барих төсөл	22,615
43	1997	Улаанбаатар	Улаанбаатар хотын тусламжийн бараа тээвэрлэх төсөл	80,055
44	1997	Өмнөговь	Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын дунд сургуулийг цахилгаан эх үүсвэрээр хангах төсөл	38,777
45	1997	Өмнөговь	Өмнөговь аймгийн Хүрмэн сумын дунд сургуулийг цахилгаан эх үүсвэрээр хангах төсөл	39,333
46	1997	Өвөрхангай	Өвөрхангай аймгийн Богд сумын дунд сургуулийг цахилгаан эх үүсвэрээр хангах төсөл	38,777
47	1997	Дундговь	Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын дунд сургуулийг цахилгаан эх үүсвэрээр хангах төсөл	38,777
48	1997	Баянхонгор	Баянхонгор аймгийн Богд сумын дунд сургуулийг цахилгаан эх үүсвэрээр хангах төсөл	38,777
49	1997	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн Галт сумын эрүүл мэндийн орчинг сайжруулах төсөл	26,635
50	1997	Улаанбаатар	Эмнэлгийн тусламжийн барааг тээвэрлэх төсөл	21,384
51	1997	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн Хатгал суманд дизель цахилгаан станц нийлүүлэх төсөл	93,000
52	1997	Өмнөговь	Өмнөговь аймгийн Манлай суманд дизель цахилгаан станц нийлүүлэх төсөл	84,000
53	1997	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн Булган суманд дизель цахилгаан станц нийлүүлэх төсөл	93,000
54	1997	Баянхонгор	Баянхонгор аймгийн Эрдэнэ-Цогт суманд дизель цахилгаан станц нийлүүлэх төсөл	93,000
55	1997	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн танин мэдэхүйн нэвтрүүлгийн сүлжээг сайжруулах төсөл	5,600
56	1997	Улаанбаатар	Хүнсний тусламжийн бараа тээвэрлэх төсөл	57,685
57	1998	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын усан хангамжийг сайжруулах төсөл	17,951
58	1998	Улаанбаатар	Улаанбаатар хотын 63-р тусгай сургуулийн мэргэжлийн сургалтыг сайжруулах төсөл	49,736
59	1998	Сүхбаатар	Сүхбаатар аймгийн 1-р сургуулийн их засварын төсөл	49,080
60	1998	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн мэргэжлийн сургалтыг сайжруулах төсөл	28,167
61	1998	Өмнөговь	Өмнөговь аймгийн эрүүл мэндийн байгууллагын харилцаа холбоог сайжруулах төсөл	50,825
62	1998	Завхан	Завхан аймгийн усан хангамжийг сайжруулах төсөл	10,388
63	1998	Улаанбаатар	Түүх, уламжлалт соёлын боловсролыг сайжруулах төсөл	67,515
64	1998	Улаанбаатар	Жижиг дунд үйлдвэрлэлийн сургалтын төвийг сайжруулах төсөл	29,990

65	1998	Улаанбаатар	Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд зориулсан ганцаарчилсан боловсрол олгох төсөл	38,330
66	1998	Улаанбаатар	Эмнэлгийн тоног төхөөрөмж тээвэрлэх төсөл	21,550
67	1998	Дорноговь	Дорноговь аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэргэжлийн сургалтыг сайжруулах төсөл	23,031
68	1998	Увс	Эмзэг бүлгийн өрхөд зориулсан газар тариалан эрхлэлтийг дэмжих төсөл	41,757
69	1998	Улаанбаатар	Монгол Глоб төсөл	32,465
70	1999	Улаанбаатар	Зүүн Азийн олон улсын 4-р симпозиумийг дэмжих төсөл	9,174
71	1999	Улаанбаатар	Монгол улсын их сургуулийн Япон хэлний сургалтыг сайжруулах төсөл	6,365
72	1999	Дорнод	Дорнод аймгийн дунд сургуулийн дотуур байрыг сайжруулах төсөл	14,561
73	1999	Улаанбаатар	Эсгий боловсруулах мэргэжлийн сургалтыг сайжруулах төсөл	20,807
74	1999	Булган	Булган аймгийн сумдын эрүүл мэндийн байгууллагын харилцаа холбоог сайжруулах төсөл	55,748
75	1999	Хэнтий	Хэнтий аймгийн сумдын эрүүл мэндийн байгууллагын харилцаа холбоог сайжруулах төсөл	55,748
76	1999	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын дунд сургуулийн сургалтыг сайжруулах төсөл	23,400
77	1999	Архангай	Архангай аймгийн Чулуут сумын нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх төсөл	39,417
78	1999	Улаанбаатар	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн эмнэлгийг сайжруулах төсөл	36,277
79	1999	Улаанбаатар	Улаанбаатар хотын Амгалан хорооны эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах төсөл	34,943
80	1999	Дундговь	Дундговь аймгийн Оош дүүргийн элэгний өвчлөлийг анагаах эмнэлгийн барилгыг тохижуулах төсөл	31,200
81	1999	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн Жаргалант сумын дунд сургуулийн тохижилтын ажлын төсөл	30,000
82	1999	Сүхбаатар	Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын эмнэлгийн барилгын тохижилтын ажлын төсөл	33,000
83	1999	Дархан-Уул	Дархан-Уул аймгийн биеийн хөдөлгөөнийг сэргээх төвийн тохижилтын ажлын төсөл	33,000
84	1999	Ховд	Ховд аймгийн Цэцэг сумын усан хангамжийг сайжруулах төсөл	20,553
85	1999	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн Чандмань сумын усан хангамжийг сайжруулах төсөл	7,715
86	1999	Төв	Төв аймгийн нөхөн сэргээх эмчилгээний төвийг байгуулахыг дэмжих төсөл	33,000
87	1999	Дундговь	Дундговь аймгийн иргэдийн нийгмийн халамжийг сайжруулах төсөл	45,800
88	1999	Бусад	Орон нутаг дахь бага дунд боловсрол нөхөн олгох үйл ажиллагааг сайжруулах төсөл	15,000
89	1999	Улаанбаатар	Хортой эм бэлдмэлийг устгах үйл ажиллагааг сайжруулах төсөл	16,739
90	1999	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн Өлгий хотын 2-р сургуулийн их засварын ажлын төсөл	20,000
91	1999	Бусад	Монголын 3 аймгийн зуданд нэрвэгдсэн иргэдэд туслах төсөл	45,479
92	2000	Баянхонгор	Баянхонгор аймгийн сумдын эрүүл мэндийн байгууллагын харилцаа холбоог сайжруулах төсөл	55,974
93	2000	Завхан	Завхан аймгийн сумдын эрүүл мэндийн байгууллагын харилцаа холбоог сайжруулах төсөл	55,856
94	2000	Увс	Увс аймгийн сумдын эрүүл мэндийн байгууллагын харилцаа холбоог сайжруулах төсөл	51,972
95	2000	Архангай	Архангай аймгийн Өгий-Нуур сумын эмнэлгийн харилцаа холбоог сайжруулах төсөл	30,182

96	2000	Улаанбаатар	Монголын Төрийн бус байгууллагуудад зориулсан семинар зохион байгуулах төсөл	14,388
97	2000	Дархан-Уул	Дархан-Уул аймгийн 12-р сургуулийн боловсролын үйл ажиллагааг сайжруулах төсөл	25,000
98	2000	Орхон	Орхон аймгийн нийгмийн эрүүл мэндийн төвийн рентген тоног төхөөрөмж суурилуулах төсөл	65,830
99	2000	Улаанбаатар	Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	73,055
100	2000	Улаанбаатар	Монгол улсын цусны төвийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	80,600
101	2000	Бусад	Зуданд нэрвэгдсэн иргэдэд туслах тусламжийн барааг тээвэрлэх төсөл	86,520
102	2000	Улаанбаатар	Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн туршилтын багаж төхөөрөмжийг сайжруулах төсөл	35,100
103	2000	Булган	Булган аймгийн Дашинчилэн сумын усан хангамжийг сайжруулах төсөл	26,736
104	2000	Увс	Увс аймгийн Завхан сумын усан хангамжийг сайжруулах төсөл	19,942
105	2000	Улаанбаатар	Монголын эмэгтэйчүүдийн холбооны мэргэжлийн сургалт олгох үйл ажиллагааг сайжруулах төсөл	18,887
106	2000	Говьсүмбэр	Говьсүмбэр аймгийн хүүхдийн төлөө төвийн үйл ажиллагааг сайжруулах төсөл	34,310
107	2000	Говьсүмбэр	Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	37,800
108	2000	Улаанбаатар	Эх нялхасын эрүүл мэндийн төвийн мэс заслын өрөөний тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	95,170
109	2000	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн Бигэр сумын эрүүл мэндийн үйлчилгээг нэмэгдүүлэх төсөл	25,163
110	2000	Увс	Увс аймгийн Сагир сумын дунд сургуулийн боловсролын үйл ажиллагааг сайжруулах төсөл	41,964
111	2000	Улаанбаатар	Монголын архинд донтогчдыг эмчлэх нийгэмлэгийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	29,574
112	2000	Улаанбаатар	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвөлгөө өгөх төвийг сайжруулах төсөл	26,472
113	2000	Улаанбаатар	Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн усан хангамжийг сайжруулах төсөл	24,233
114	2000	Улаанбаатар	Улаанбаатар хотын ариун цэвэр эрүүл ахуйн шинжилгээний тоног төхөөрөмж нэвтрүүлэх төсөл	95,000
115	2000	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн Мандал сумын нийгмийн эрүүл мэндийн төвийн засварын ажлын төсөл	32,453
116	2000	Улаанбаатар	Элэгний өвчлөлийг эмчлэх уламжлалт анагаах ухааны төвийн үйл ажиллагааг сайжруулах төсөл	55,539
117	2000	Бусад	Монголын зудын хохиролыг бууруулах яаралтай нэгдсэн төлөвлөгөөний төсөл	202,031
118	2000	Бусад	Монгол улсад яаралтай тусламжийн хүнс тээвэрлэх төсөл	86,520
119	2000	Бусад	Монгол улсад хүнсний яаралтай тусламж үзүүлэх төсөл	70,566
120	2000	Төв	Хөлдсөн сургуулийн халаалтын барилга барих төсөл	95,197
121	2001	Увс	Увс аймгийн Малчин сумын сургуулийн барилгыг сайжруулах төсөл	52,692
122	2001	Улаанбаатар	Монголын гудамжны хүүхдүүдийн хоноглох байрыг сайжруулах төсөл	84,000
123	2001	Төв	Төв аймгийн 3 сумын усан хангамжийг сайжруулах төсөл	27,399
124	2001	Ховд	Ховд аймгийн нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн харилцаа холбооны системийг сайжруулах төсөл	55,208
125	2001	Улаанбаатар	Улаанбаатар хотын Гачуурт тосгоны усан хангамжийг сайжруулах төсөл	79,862
126	2001	Улаанбаатар	Гэмтлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	65,830

127	2001	Улаанбаатар	Улсын нэгдсэн төв эмнэлгийн хэл ярианы согог засах лабораторийг байгуулах төсөл	89,000
128	2001	Дорноговь	Дорноговь аймгийн Өргөн сумын боловсролын байгууллагыг сайжруулах төсөл	92,425
129	2001	Дархан-Уул	Дархан хотын хүүхдийн төлөө төвийг сайжруулах төсөл	79,136
130	2001	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн 3 сумын дотуур байрны засварын ажлын төсөл	21,121
131	2001	Улаанбаатар	Монгол хүний намтар судлалын төвийн техникийн хамтын ажиллагааны төсөл	10,330
132	2001	Улаанбаатар	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбооны үйл ажиллагааны арга барилыг дээшлүүлэх төсөл	17,247
133	2001	Улаанбаатар	Харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр сургалтыг дээшлүүлэх төсөл	27,975
134	2001	Улаанбаатар	Бага орлоготой эмэгтэйчүүдэд хөдөлмөр сургалт олгох төсөл	41,950
135	2001	Хэнтий	Хэнтий аймгийн Хэрлэн сумын дунд сургуулийн их засварын ажлын төсөл	40,946
